



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/558

Булган сум

Барилга паспортжуулах тухай


Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 42 дугаар зүйлийн 42.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилга байгууламжийг паспортжуулах ажлын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн хуучин барилгыг 600,000 (зургаан зуун мянга) төгрөгөөр Шинжлэн ухаан технологийн их сургуулийн Дархан хот дахь салбар сургуулийн барилгын материал судлалын төвтэй гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Барилга байгууламжид үзлэг хийж хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын дүнэлтийг гаргуулах ажлыг шуурхай зохион байгуулж, хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Г.Ганбаатар)-т даалгасугай.

3.Барилга байгууламжинд үзлэг хийсэн дүгнэлтийг үндэслэн батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийг дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

8323010587